



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 оны 12 дугаар  
сарын 01-ны өдөр

Дугаар ХХТ/1886

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН САЙД Ц.ЦОГЗОЛМАА ТАНАА

Албан даалгаврын хэрэгжилт  
ирүүлэх тухай

Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах нь Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой зорилтуудын нэг болж байна.

Энэ зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг гарган орон даяар хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.

Иймд уг албан даалгаврын мөрөөр хийсэн ажлын тайлан, хэрэгжилтийг заалт бүрээр гарган, дэлгэрэнгүй танилцуулга, тайлбарын хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2017 оны 12 дугаар сарын 11-ний дотор ирүүлнэ үү.

Албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнахдаа үүрэг, чиглэлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан шийдвэр, үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийг төрийн хариуцлагатай албан хаагч нэг бүрээр тодорхой дурдаж, салбарын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, аж ахуйн нэгж болон нутаг дэвсгэрийн хэмжээний тайлан, мэдээллийг нэгтгэн ирүүлэхийг анхаарна уу.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР